



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 4619

Номгон

Иргэний нисэхийн Үндэсний төв ТӨХХК-ийн
Баянхонгор аймаг дахь нисэх буудалд
тоног төхөөрөмжийн дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын ажиллах, орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор Иргэний нисэхийн Үндэсний төв ТӨХХК-ийн Баянхонгор аймаг дахь нисэх буудалд тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэх тоног төхөөрөмжийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Тоног төхөөрөмжийн дэмжлэгт зарцуулах 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д зөвшөөрсүгэй.

4.Дэмжлэгээр олгогдсон тоног төхөөрөмжийг байгууллагын эд хөрөнгийн бүртгэлд бүртгэж, ашиглахыг Иргэний нисэхийн Үндэсний төв ТӨХХК-ийн Баянхонгор аймаг дахь нисэх буудлын дарга (Д.Мөнхжаргал)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010879

Аймгийн Засаг даргын 2086 оны 05 дугаар
сарын 29 ний өдрийн 2/319 дүгээр
захирамжийн хавсралт



ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Тоног төхөөрөмжийн нэр	Мөнгөн дүн
1	3	4
1	Компьютер	4,000,000

___оОо___

